



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: [info@frc.mn](mailto:info@frc.mn), <http://www.frc.mn>

2022.08.02 № ЦАТ-11/02/001 .  
танай 2022.07.22 -ны № 07/01 -т

Г Гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг  
бүртгэсэн тухай

Танай компанийн брокерын өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлт, холбогдох баримт бичгийг Хорооны 2020 оны 150 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам” болон Хорооны 179 дүгээр тогтоолоор баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын дагуу хянаж үзэхэд гүйцэтгэх захирлаар томилохоор ирүүлсэн Долгорсүрэнгийн Сэржбүдээ нь холбогдох журмын шаардлагыг хангаж байгаа тул одоогийн гүйцэтгэх захирал Пүрвээгийн Очирхуягийг өөрчилж, гүйцэтгэх захирал Долгорсүрэнгийн Сэржбүдээ гэж Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэсэн болно.

Цаашид дээрх журмын 6.1-т “Дараах өөрчлөлтүүдийг оруулахын өмнө тухай бүр Хороонд мэдэгдэж, бүртгүүлнэ”, 6.1.1-т “эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдөх” гэж заасны дагуу эрх бүхий албан тушаалтан болон хаяг өөрчлөгдөх тухай бүр Хороонд бүртгүүлж ажиллахыг анхаарна уу.

